



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 8 сарын 28 өдөр

Дугаар 235

Улаанбаатар хот

Төлөөлөгчийн газрыг бүртгэх тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.2.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Даатгалын хохирол үнэлэгч “Ашид билгүүн” ХХК Өмнөговь аймгийн Цогтцэций сум, 3 дугаар баг, “Цогтхан” ХХК-ийн байранд нэг, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 01 дүгээр хороо, 5 дугаар байрны 103 тоотод нэг, нийт хоёр төлөөлөгчийн газар нээснийг бүртгэсүгэй.

2. Төлөөлөгчийн газар нээх болсонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Хороонд ирүүлэхийг “Ашид билгүүн” ХХК /Ч.Жамъян/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН